МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН ХООРОНДЫН ИРГЭН БОЛОН АЖ АХУЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ БАТЛАМЖ ЖУУХ БИЧГИЙГ СОЛИЛЦОХ ТУХАЙ ПРОТОКОЛ

Дор гарын үсэг зурсад, Монгол Улсын элчин сайд Ж.Гөлгөө, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын нарийн бичгийн дарга Р. М. Абхянкар нар 2001 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хоорондын иргэн болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээний Батламж жуух бичгийг солилцохоор 2004 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр уулзав.

Батламж жуух бичгүүд үнэн зөв байгааг шалгасны дараа тэдгээрийг солилцов.

Үүнийг нотлон дор гарын үсэг зурагсад энэхүү монгол, хинди, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн Протоколд гарын үсэг зурав.

Шинэ Дели хотноо 2004 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр үйлдэв.

Жанцан Гөлгөө
Монгол Улсын элчин сайд

Р.М. Абхянкар
Бүгд Найрамдах Энэтхэг
Улсын Засгийн газрын
нарийн бичгийн дарга

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ